

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.04.23

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг, хурал хийхээр товлосон зарын дагуу 2025.4.23-ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимаас цахим хэлбэрээр шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2025.04.23 ны өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9.895 хувьцаа эзэмшигчдээс 2.938.583 ширхэг хувьцаа эзэмшсэн 29 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон байна. Энэ нь нийт хувьцааны 77,31 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурал дарга тус компаний дэд захирал Адъяахүү нээж үг хэлэв.

Хурлын дарга : Хувьцаа эзэмшигч та бүхэн маань "Махимпэкс" ХК-ийн пэйж хуудсанд хандан цахимаар болон өөрийн биеэр саналаа өгөцгөөсөн, одоо хурлын үйл ажиллагаанд цахимаар оролцохыг урьж байна гэв. Дараа нь хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг байраа эзлэхийг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг батлах
 4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
-
1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2025 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Г.Бүдрагчаа илтгэв.
 2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн нягтлан бодогч С.Мөнхжаргал тайлагнав.
 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг танилцуулав
 4. "Ногдол ашиг хуваарилах" тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Хувьцаа эзэмшигч : Компанийн экспорт жил бүр нэмэгдсэн байна, яагаад ногдол ашиг нэмэгдэхгүй байна вэ? Олон жил нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг 100₮ л байх юм,

Ерөнхий нягтлан бодогч С.Мөнхжаргал : Манай компанийн 80 жил ирэх онд болно, үүнтэй холбоотойгоор төсөл хөтөлбөрүүдийг 2024 оноос эхлэн хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт их хийгдэж байгаа тул ногдол ашгийг нэмээгүй хэвээр олгохоор Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэсэн. Хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдэхээр ногдол ашиг нэмэгдэнээ.

Хувьцаа эзэмшигч : Компанийн 80 жилийн ойгоо угтаж хэрэгжүүлж буй төлөвлөгөөнийхөө талаар танилцуулаач.

Хариулт : Манай компанийн хамт олон түүхт 80 жилийн ойгоо угтаж МИК-80 нэгдсэн төслийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн эхний үе шат бүрэн хэрэгжиж "Боловсруулах үйлдвэр" ашиглалтан орж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Дараагийн үе шат болох "Мах ангилан савлах" үйлдвэр, 8150 тн -ын багтаамж бүхий агуулахын бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байгаа бөгөөд эхний ээлж болох ээлжиндээ 40тн мах шулж ангилах иж бүрэн "Мах ангилан боловсруулах" үйлдвэр, ажилчдын нийтийн үйлчилгээний төв, "Хүнсний нэгдсэн лавлагаа, лаборатори"-ийг 30.000 гаруй м2 талбайд барьж байгуулах ажлын явц 80%-тай явандаж байна, энэ оны 9-р сарын 1-нд ашиглалтанд хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Мөн "Хөргүүртэй агуулах" болон бусад цогцолбор ажлуудыг хөтөлбөрийн дагуу төлөвлөсөн хугацаандаа барьж байгуулахаар ажиллаж байна. Эдгээр бүтээн байгуулалтыг 80 жилийн ойн босгон дээр ашиглалтанд оруулахаар зорин ажиллаж байна.

Асуулт : Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг яагаад танхимаар хуралдуулахгүй байна вэ?

Хариулт : Бид төлөвлөгөөт бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаатай холбогдуулан аюулгүй байдлын үүднээс хувьцаа эзэмшигчдийг олноор цуглуулах боломжгүй байгаа тул энэ удаад цахимаар хийх шийдвэр гаргасан.

Асуулт : Бүтээн байгуулалтын ажил их хийгдэж байгаа юм байна, өгөөжээ хэдийнээс өгөх вэ?

Хариулт : Бүтээн байгуулалтын ажил 2026 онд дуусна. Бид 8-10 жилийн хугацаанд нөхөх тооцоотойгоор төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Асуулт : Хуучин "Хөргөх үйлдвэрийн барилгыг нураах уу их удсан барилга шүү дээ.

Хариулт : Мэргэжлийн байгууллагаар барилгын насжилтыг тогтоолгосон, хэдий 1968 онд ашиглалтанд орж 57 дахь жилдээ ашиглаж байгаа боловч 8-10 жил ашиглах боломжтой гэсэн дүгнэлт гарсан учраас хэвийн ажиллуулна.

Асуулт : Үйлдвэрийн түүхий эд болох амьд малыг хэрхэн тээвэрлэж оруулж ирдэг вэ?

Хариулт : Манай компани амьд мал ачих зориулалтын тээврийн хэрэгсэлтэй. Малчид, мал бэлтгэгч нартай график байгуулан хамтран ажилладаг.

Малын эмч Лхагвасүрэн : Манай компани амьд мал ачих зориулалтын тээврийн хэрэгсэлтэй. Малчид, мал бэлтгэгч нартай график байгуулан хамтран ажилладаг.

Асуулт : Махны нэрийн барааны дэлгүүрүүд хаагуур байрладаг вэ? Дотоодын махны борлуулалтаа хэрхэн төлөвлөсөн бэ?

Борлуулалтын албаны дарга Алтан-Эрдэнэ : Нэрийн барааны дэлгүүрүүд ХУД, БЗД, СБДүүргийн Номин сүлжээ дэлгүүрүүд болон "Хурд Маркет" ХХК-ийн Ореш салбар дэлгүүрүүдэд байрлаж байгаа, энэ онд дотоодын махны борлуулалтыг болон нэрийн барааны дэлгүүрүүдийн тоо, харилцагч байгууллагын тоо, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хурлын дарга Адъяахүү : За хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуулт үүгээр дуусч байна. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" тооллогын комиссын №2 тоот тогтоолыг уншиж танилцуулав./уг тогтоолыг хурлын материалд хавсаргав.

Тооллогын комиссын дарга : Компанийн нийт 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9.895 хувьцаа эзэмшигчдээс хуралд 2.938.583 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 29 хувьцаа эзэмшигч оролцов

Тооллогын комиссоос тараасан саналын хуудас 29 ширхэг, ирсэн саналын хуудас 29 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын хуудас 29 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын хуудас байхгүй байна.

1. Компаний 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 2.983 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй
2. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 2.983 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй
3. 2025 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсвийг батлахыг зөвшөөрсөн 2.938.583 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан түдгэлзсэн санал байхгүй
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр хуваарилахыг зөвшөөрсөн 2.938.583 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй байна. Нийт ирсэн саналыг үндэслэн

ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай. гэж уншиж танилцуулав.

Үүний дараа хурлын дарга Адъяахүү хурлаас гарсан шийдвэрийг уншиж танилцуулав.

Хурлын дарга : Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас шийдвэр гарч байна, уншиж сонсоё, Тооллогын комиссын дүнг үндэслэн

ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг баталсугай.
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр тогтоосугай гэж уншсанаар хурал 15 цаг, 30 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



АДЪЯАХҮҮ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



И.ӨЛЗИЙБАЯР

